

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар

Багахангай дүүрэг

№	Бодлогын баримт бичгийн нэр	Хэрэгжилт	Хувь
1	Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнөөс дүүрэгт хамааралтай 85 заалтыг хяналтад авч, төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсийн холбогдох мэргэжилтэнд тайлагнав. Хяналтад авсан заалтаас 100 хувийн хэрэгжилттэй-4, 90 хувийн хэрэгжилттэй-42, 70 хувийн хэрэгжилттэй-10, 50 хувийн хэрэгжилттэй-7, 30 хувийн хэрэгжилттэй-12, тасарсан-0, үнэлэх боломжгүй-10, ерөнхий үнэлгээ 74,5 хувьтай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв.	74,5
2	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хамжээний төлөвлөгөө	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 5 заалтыг хяналтад авч 2023 оны 03, 04, 05 дугаар сарын байдлаар нийт 3 удаа биелэлтийг нэгтгэн тайлагнасан. МУЗГҮАХ-т тусгагдсан заалтуудаас гэр хорооллын орчин нөхцлийг сайжруулах зорилгоор 2023 оны 2-оос 4 дүгээр улиралд 1 өрхийн хашаанд био жорлон нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ онд дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд дугуйн зам, явган хүний зам, гүйлтийн замыг шинээр барих төсөв, санхүүжилт шийдэгдээгүй тул төлөвлөгөөнд тусгагдаагүй. Дүүргийн Өндөрлөгийн гадна орчны ногоон байгууламж, тохижилтын ажлын зураг төсөв боловсруулах ажлын үнэлгээний хороо дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/07 дугаар захирамжаар байгуулагдсан. Тендерийг 2023.05.15-ны өдөр нээхэд 2 санал ирснийг үнэлж, “Ти эл прожект” ХХК-ийн материал хамгийн сайн үнэлэгдсэн тул 2023.05.18-ны өдөр гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. Зөвлөх үйлчилгээний гэрээ 2023.05.29-07.29-ний өдрийг хүртэл байгуулагдана. Хэрэгжилт 60 хувьтай байна.	60
3	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2023 оны 03, 04, 05 дугаар сарын байдлаар 3 удаа нэгтгэн тайлагнав. МУХТЖҮЧ-9.2.4, ЗГҮАХ-6.1.7-т заасан Хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, амьдрах таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх зорилгын холбогдох заалтын үзүүлэлтүүдээр биелэлтийг гаргаж тайлагнав. 2023 онд тус дүүрэгт шинээр барих авто зам, дугуйн зам, явган хүний замын төсөв, санхүүжилт шийдэгдээгүй, Нийслэлийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх 100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн эвдрэл гэмтэл, замын нөхөөс хийх ажлын тендер зарлагдаж, 3 компани	50

	материал ирүүлсэн. Тендерийг үнэлж 2023.05.16-ны өдөр "Пирамид прожект" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. Гэрээ 2023.05.29-08.20-ны өдрийг хүртэл байгуулагдана. Хэрэгжилт 50 хувьтай байна.	
ДУНДАЖ ХУВЬ		61,5

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг хуваарийн дагуу нэгтгэн биелэлтийг тухай бүр сайтад нийтэд ил тод байршуулахаар зорин ажиллаж байна.

БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР